**ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД, НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА, УЛААНБААТАР ХОТЫН ЗАХИРАГЧИЙН ХАМТАРСАН ТУШААЛ, ЗАХИРАМЖ**

1994 оны 10 дугаар сарын 11 өдөр | Дугаар А/110/А-183 | Улаанбаатар хот

Тогтоол хэрэгжүүлэх арга хэмжээний тухай

Халдварт өвчинтэй тэмцэх, сэргийлэх ажлыг сайжруулах зарим арга хэмжээний тухай Монгол улсын Засгийн газрын 1994 оны 8 дугаар сарын 24-ний өдрийн 153 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор ТУШААХ нь:

1. Үйл ажиллагаа, зохион байгуулалт нь давхардаж байгааг харгалзан Халдварт өвчин судлалын төв, Халдварт өвчнийг анагаах клиникийн эмнэлэг, Улсын эрүүл ахуй, халдвар судлалын хяналтын газар, Эрүүл ахуй, халдвар, нян судлалын улсын институт, Арьс өнгөний эмгэг судлалын төв, Мэдээлэл, тооцооллын төв, Нийслэлийн Эрүүл ахуй, халдвар судлалын хяналтын газрыг тус тус татан буулгаж, Улсын эрүүл ахуй, халдвар судлалын хяналтын газар, Эрүүл ахуй, халдвар, нян судлалын улсын институт, Халдварт өвчнийг анагаах клиникийн эмнэлэг, Мэдээлэл, тооцооллын төв болон Арьс өнгөний эмгэг судлалын төвийн өнгөний халдварын хэсэг, Арьс өнгөний клиникийн эмнэлгийн өнгөний өвчний тасаг, Халдварт өвчин судлалын төвийн улсын үйлчилгээ хариуцсан халдвар судлал, дүн бүртгэл, сэргийлэх тарилга, бруцеллёзын хэсгийн холбогдох орон тоо, төсөв, багаж хэрэгслийг нэгтгэх замаар Эрүүл ахуй, халдвар, нян судлалын үндэсний төвийг Халдварт клиникийн эмнэлэгтэйгээр байгуулж, 1994 оны 10 дугаар сарын 16-наас эхлэн ажиллуулсугай.

2. Арьс өнгөний эмгэг судлалын төвийн арьсны эмгэгийн хэсгийг Арьс өнгөний клиникийн эмнэлэгт нэгтгэж Арьсны өвчин судлалын төв болгон өөрчлөн байгуулж, 1994 оны 10 дугаар сарын 16-наас эхлэн

ажиллуулсугай.

3. Халдварт өвчин судлалын төвийн Улаанбаатар хотын үйлчилгээ хариуцсан хэсгийг Нийслэлийн эрүүл ахуй, халдвар судлалын хяналтын газартай нэгтгэн Нийслэлийн Эрүүл ахуй, халдвар судлалын төв болгон зохион байгуулсугай.

4. Эмчилгээний гоо засалын газрыг Улаанбаатар хотын харъяалалд ажиллуулсугай.

5. Эрүүл ахуй, халдвар, нян судлалын үндэсний төвийн дүрмийг нэгдүгээр, Арьсны өвчин судлалын төвийн дүрмийг хоёрдугаар, Нийслэлийн эрүүл ахуй, халдвар судлалын төвийн дүрмийг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

6. Эрүүл ахуй, халдвар, нян судлалын үндэсний төвийн захирлаар С.Цоодол, Арьсны өвчин судлалын төвийн захирлаар Т.Ядамсүрэн, Нийслэлийн эрүүл ахуй, халдвар судлалын төвийн захирлаар Ч.Уржээ нарыг тус тус томилсугай.

7. Эрүүл мэндийн яамны улсын халдварын фондыг Эрүүл ахуй, халдвар, нян судлалын үндэсний төвд шилжүүлсүгэй.

8. Энэхүү зохион байгуулалтын дагуу орон тоо, төсөв, хөрөнгө шилжүүлэх, ажил хүлээлцүүлэх яамны комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

- Комиссын дарга — Г.Дашзэвэг (дэд сайд)
- Комиссын орлогч дарга — Г.Буян-Өлзий (Нийслэлийн эрүүл мэндийн газрын дарга)
- Комиссын нарийн бичгийн дарга — Ц.Содномпил (Эрүүл мэндийн яамны Нийгмийн эрүүл мэндийн газрын дарга)
- Гишүүдэд — Н.Долоонжин (Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын санхүүгийн хэлтсийн мэргэжилтэн)
  - Н.Жанцан (Эрүүл мэндийн яамны Эмнэлгийн тусламжийн газрын ажилтан)
  - Д.Амар (Эрүүл мэндийн яамны Эрүүл мэндийн эдийн засаг, хамтын ажиллагааны газрын ажилтан)

- Г.Цэцэгдарь (Эрүүл мэндийн яамны Хүн хүч, анагаах ухааны бодлогын хэлтсийн ажилтан)
- И.Даваадорж (Эрүүл мэндийн яамны Нийгмийн эрүүл мэндийн газрын ажилтан)
- А.Буянаа (Эрүүл мэндийн яамны Нийгмийн эрүүл мэндийн газрын ажилтан)

9. Комисс (н.Дамэзвэг)-т даалгах нь:

а) байгууллага хооронд шилжүүлж буй орон тоо, төсөв, эд хөрөнгийн жагсаалт гаргуулж, тухайн байгууллагуудын 1993 оны жилийн эцсийн тооллогын материал, санхүүгийн тайлан, баланстай тулган шалгаж, хүлээлцүүлэх арга хэмжээг 1 сарын дотор багтаан дуусгаж, дүнг хотын Засаг даргын зөвлөл, сайдын зөвлөлд танилцуулах.

б) Шинээр зохион байгуулагдсан байгууллагуудын санхүүжилт, 1995 оны төсвийн талаар холбогдох яам, байгууллагуудтай зөвшилцөн тохирч, шийдвэрлэх арга хэмжээ авах.

в) хуучин Арьс өнгөний эмгэг судлалын төвийн байшинг Нийслэлийн өвчний газар, Өмч хувьчлалын комисст зохих ёсоор хүлээлгэн өгөх.

10. Арьс өнгөний эмгэг судлалын төвийн барилгыг эрүүл мэндийн үйлчилгээний зориулалтаар ашиглуулахаар дуудлагын худалдаагаар борлуулж, борлуулалтаас олсон хөрөнгийг Нийслэлийн эрүүл мэндийн байгууллагуудын үндсэн хөрөнгийн их засварт зарцуулахыг Засаг даргын дэргэдэх Эрүүл мэндийн газар (н.Буян-Өлзий), Өвчний газар (н.Найдан), Өмч хувьчлалын комисс (н.Ойдовсамбуу)-т үүрэг болгосугай.

11. Аймаг, орон нутагт "Халдварт өвчинтэй тэмцэх, сэргийлэх ажлыг сайжруулах зарим арга хэмжээний тухай" Засгийн газрын 1994 оны 153 дугаар тогтоол, энэхүү тушаалыг хэрэгжүүлэх зохион байгууллалтын асуудалтай холбогдуулан Эрүүл мэндийн сайдын зөвлөмж энэ оны 10 дугаар сард багтаан боловсруулахыг Эрүүл ахуй, халдвар, нян судлалын үндэсний төв (н.Цоодол), Арьсны өвчин судлалын төв (н.Ядам-

сурэн), Эмнэлгийн тусламжийн газар (н.Оргил), Нийгмийн эрүүл мэндийн газар (н.Содномпил)-т даалгасугай.

12. Энэ тушаал гарсантай холбогдуулан Эрүүл ахуй, халдвар, нян судлалын улсын институт байгуулах тухай Эрүүлийг хамгаалах яамны сайдын 1968 оны 2 дугаар сарын 14-ний өдрийн 88 дугаар тушаал, Нэдэвлэл, тооцооллын төв байгуулах тухай Эрүүлийг хамгаалах яамны сайдын 1990 оны 6 дугаар сарын 25-ны өдрийн А/91 дугээр тушаал, "Эрүүл ахуй, халдвар судлалын хяналтын байгууллагуудын талаар авах зарим арга хэмжээний тухай" Эрүүл мэндийн сайдын 1990 оны 11 дүгээр сарын 16-ны өдрийн А/165 тоот тушаалын 2,3,6 дугаар заалт, Нийслэл хот дахь эрүүл мэндийн зарим байгууллагуудын зохион байгуулалтыг шинэчлэн өөрчлөх тухай Эрүүл мэндийн сайд, Улаанбаатар хотын АДХ-ын гүйцэтгэх захиргааны 1991 оны А/39/83 дугаар тушаал, тогтоолын III хавсралтаар баталсан жагсаалтын 8, 10, 35, 37 дугаар зүйл, "Биобэлдмэлийн хангамжийн талаар авах зарим арга хэмжээний тухай" Эрүүл мэндийн сайдын 1992 оны 6 дугаар сарын 26-ны өдрийн А/120 дугаар тушаалын 1 дүгээр хавсралт, "Нийслэл, дүүргүүдийн эрүүл ахуй, халдвар судлалын хяналтын байгууллагуудын талаар авах зарим арга хэмжээний тухай" Нийслэлийн Засаг даргын 1992 оны 12 дугаар сарын 3-ны өдрийн А/75 тоот захирамжийн нэгдүгээр заалтын "Нийслэлийн эрүүл ахуй, халдвар судлалын хяналтын газар" гэсэн хэсэг, "Хилийн эрүүл ахуй, халдвар судлалын хяналтын талаар авах зарим арга хэмжээний тухай" Эрүүл мэндийн сайдын 1993 оны 6 дугаар сарын 24-ний өдрийн А/87 дугаар тушаалын 2 дугаар заалт, Улсын үйлдвэрийн газар болгох тухай Эрүүл мэндийн сайдын 1993 оны 11 дүгээр сарын 2-ны өдрийн А/156 тоот тушаалын 2 дугаар заалтыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

МОНГОЛ УЛСЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД П.НЯМДАВАА

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА, УЛААНБААТАР ХОТЫН ЗАХИРАГЧ П.БААСАНЖАВ

Эрүүл мэндийн сайд, Нийслэлийн Засаг дарга, Улаанбаатар хотын захирагчийн 1994 оны А-110/А-183 тоот хамтарсан тушаал, захирамжийн нэгдүгээр хавсралт

# ЭРҮҮЛ АХУЙ, ХАЛДВАР, НЯН СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН ДҮРЭМ

## Нэг. Нийтлэг үндэслэл

1. Эрүүл ахуй, халдвар, нян судлалын үндэсний төв нь (цаашид энэ дүрэмд Төв гэнэ) эрүүл ахуй, халдвар судлалын улсын хяналт, халдварт өвчинтэй тэмцэх, сэргийлэх, эмчлэх арга хэмжээний үндэсний бодлогыг боловсруулж, зохион байгуулалт, мэргэжил, арга зүйн хувьд удирдах, эрүүл ахуй, халдвар, нян судлал, анагаах ухааны биотехнологийн асуудлаар эрдэм шинжилгээ, судалгааны төсөлт ажлыг хэрэгжүүлэх, хүн эмнэлгийн биобэлдмэлийг үйлдвэрлэх, хангах үүрэг бүхий эрүүл ахуй, халдвар, нян судлалын мэргэжлийн төв байгууллага мөн.

2. Төвийн үйл ажиллагааны үндсэн зорилт нь:

- эрүүл ахуй, халдвар судлалын хяналтыг боловсронгуй болгож, халдварт болон хүрээлэн буй орчны нөлөөллөөс шалтгаалсан өвчнөөс сэргийлэх, тэмцэх, эмчлэх арга хэмжээний үр ашиг, шинжлэх ухаан, технологийн түвшинг дээшлүүлэх замаар хүн амын өвчлөл, эндэгдлийг бууруулна.

- эрүүл ахуй, халдвар, нян судлал, анагаах ухааны биотехнологи, халдварт өвчний эмнэлзүйн тулгамдсан асуудлаар эрдэм судлалын ажлыг улсын эрэлт хэрэгцээнд нийцүүлэн захиалга, даалгаврын дагуу төслөөр гүйцэтгэж, онолын түвшин, практик үр өгөөжийг байнга дээшлүүлнэ.

- эрүүл мэндийн байгууллагуудыг чанарын шаардлага хангасан, эдийн засгийн хувьд үр ашигтай биобэлдмэлээр хангаж байхад оршино.

3. Төв үйл ажиллагаандаа Монгол улсын хууль тогтоомж, хөтөлбөр, эрүүл ахуй, халдвар судлалын улсын хяналтын дүрэм, эрүүл

ахуй, халдвар судлалын холбогдолтой олон улсын эрх зүйн акт, Эрүүл мэндийн сайдын тушаал, нийслэлийн Засаг даргын шийдвэрийг удирдлага болгоно.

4. Төв нь эрүүл ахуйн болон халдварт өвчний хяналтын газар, хилийн ариун цэврийн хяналтын алба, эрдэм шинжилгээний салбар, био-бэлдмэлийн үйлдвэр, эрүүл мэндийн мэдээллийн алба, халдварт өвчнийг анагаах клиникийн эмнэлэг зэрэг үндсэн нэгжтэй байна.

5. Төв нь улсын төсөв, эрдэм шинжилгээний улсын сангаас төсөвөөр, өөрийн аж ахуйн тооцоон дээр санхүүжинэ.

6. Төвийг эрүүл мэндийн сайд, Нийслэлийн Засаг даргын томилсон захирал удирдах, төвийн зорилт, үүргийг хэрэгжүүлэх ажлыг дээд байгууллагын өмнө хариуцна. Төвийн захирал нь Эрүүл ахуй, халдвар судлалын улсын ерөнхий байцаагч (цаашид энэ дүрэмд Ерөнхий байцаагч гэнэ) байна. Ерөнхий байцаагч, түүний орлогчдыг Эрүүл мэндийн сайд томилно.

7. Ерөнхий байцаагч нь эрх хэмжээнийхээ асуудлаар Монгол улсын хууль, тогтоолжид нийцүүлэн тус улсын хэмжээнд болон Эрүүл ахуй, халдвар судлалын хяналтын газар, салбар (цаашид хяналтын байгууллага гэнэ) тэдгээрийн албан тушаалтнаас үйл ажиллагаандаа дагаж мөрдөх тушаал, шийдвэр гаргаж эрүүл ахуй, халдвар судлалын норм, дүрэм, шинжилгээний аргыг батлаж, биелэлтийг зохион байгуулж хяналт тавина.

8. Ерөнхий байцаагч нь эрүүл ахуй, халдвар судлалын хяналтын асуудлаар яам, тусгай газар, аймаг, нийслэлийн Засаг даргатай шууд харилцана.

9. Төв нь эрдэм судлалын ажлын бодлого, төсөл боловсруулж, хэрэгжилтийг зохион байгуулах, үнэлгээ, дүгнэлт өгөх үүрэг бүхий

эрдмийн зөвлөл, захиргаа, дотоод ажил, санхүүгийн үйл ажиллагааг хамтын удирдлагын зарчим дээр зохион байгуулах үүрэгтэй захирлын зөвлөлтэй байна.

10. Эрдмийн зөвлөлийн бүрэлдэхүүнийг эрдмийн хамт олон 3 жилийн хугацаатай сонгож, захирал батламжилна. Эрдмийн зөвлөлийн дарга нь төвийн захирал байна. Захирлын зөвлөлийн гишүүдийг төвийн захирал томилж удирдана. Эрдмийн зөвлөл, захирлын зөвлөлийн ажиллах журмыг захирал батлан мөрдүүлнэ.

11. Төвийн захирал төвийн бүтэц, зохион байгуулалт, албад, нэгж харьяа байгууллагын дүрэм, ажиллагааны журмыг батлан мөрдүүлж хяналт тавина. Тэдгээрийн удирдлага, төвийн дэд захирлуудыг томилно.

12. Төв нь хуулийн этгээдийн эрх эдэлж, зохих журмын дагуу хийгдсэн тэмдэг, албан бичгийн хуур, хэвлэмэл хуудас хэрэглэнэ.

Хоёр. Үндэсний төвийн үүрэг, эрх

А. Төв нь дор дурдсан үүрэг гүйцэтгэнэ.

1. Эрүүл ахуй, халдвар судлалын улсын хяналтын дүрмийг хэрэгжүүлэх ажлыг удирдан зохион байгуулах;

2. Нийгэм-экологи, эрүүл мэнд, эрүүл ахуй, халдвар, нян, хор судлалын холбогдолтой хууль, тогтоол, норм, норматив, стандарт, дүрэм, заавар, нөхцөлийг яам, улсын хороо, тусгай газар, аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар, улс, олон нийт, хоршоолол, хувийн, түүний дотор гадаадын хувь нийлүүлсэн, хамтарсан үйлдвэр, аж ахуйн нэгж, байгууллага, албан тушаалтан, хувиараа хөдөлмөр эрхлэгчид, иргэдээс (цаашид байгууллага, иргэд гэнэ) хэрхэн мөрдөж байгааг хянан шалгах, биелэлтийг хангуулах;

3. Хөдөлмөр, орчин, ахуй, сургалт, хооллолт, амралтын эрүүл ахуйн нөхцөл, байгаль, нийгмийн хүчин зүйлийн сөрөг нөлөөллийн улмаас хүний эрүүл мэндэд учруулж буй хор холбогдлыг судалж, хяналт

тавих, урьдчилан сэргийлэх арга хэмжээний чиглэл, бодлогыг тодорхойлох;

4. Халдварт өвчин болон хүн амын өвчлөл, эндэгдэлд нөлөөлөх суурь эзэлж байгаа бусад өвчинтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх талаар зохиож байгаа ажилд хяналт тавих, тэдгээр өвчний малтгаан, нөхцөлийн байдалд ажиглалт, судалгаа хийж, тандалтын систем тогтоож хэрэгжүүлэх, шаардлагатай асуудлаар яаралтай арга хэмжээг зохион байгуулах, гүйцэтгэх;

5. Эрүүл мэндийн урьдчилсан ба байнгын хяналтад албан заавал хамрагдах ажил, үйлчилгээ, байгууллага, ажилчдын хамт олон, ажлын байрыг тодорхойлж, хянах ажлыг зохион байгуулах;

6. Хүний эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлж болзошгүй цацраг идэвхт ба химийн бодис, цахилгаан соронзон орны үүсгүүр, нянгийн амьд өсгөвөр, тэдгээрийн хор, хүнсний нэмэлт, газар тариаланд хэрэглэж буй химийн бордоо, хортонтой тэмцэх бодист улсын бүртгэл хөтлүүлэх, тэдгээрийн нөлөөллөөс үүсч болзошгүй өвчин эмгэгийн байдлыг тандах, байгууллага, иргэдийг энэ тухай мэдээллээр хангах, хүн амын өвчлөл, хяналтаар илэрсэн зөрчил, авсан арга хэмжээнд үнэлэлт, дүгнэлт өгөх;

7. Аж ахуйн нэгжүүдээс бэлтгэж байгаа хоол, хүнсний зүйл, түүхий эд, ахуйн болон гоо сайхны зориулалттай болон бусад бүтээгдэхүүн, хор, бордоо, нийлэг эдлэлийн хэрэглээний аюулгүй байдлыг баталгаажуулах, чанарын баталгаагүй бүтээгдэхүүнийг үйлдвэрлэх, хүн амын хэрэгцээнд гаргахыг хориглох, сэргийлэх ажлыг зохион байгуулах;

8. Эрүүл ахуй, халдвар судлалын хяналтын байгууллагуудыг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, лабораторийн материаллаг баазыг бэхжүүлэх, боловсон хүчнийг бэлтгэх бодлого чиглэл боловсруулж

хэрэгжүүлэх, хөдөлмөрийн нөхцөл, хөдөлмөр хамгааллыг сайжруулах арга хэмжээ авч хэрэгжүүлэх;

9. Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, хүрээлэн байгаа орчныг бохирдлоос сэргийлж эрүүлжүүлэх талаар эрдэм судлалын ажил явуулж, үр дүнг эрүүлийг хамгаалахын практикт нэвтрүүлж, түүнийг хэрэгжүүлэх ажилд оролцох;

10. Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, өвчний дэгдэлтийг таслан зогсоох талаар төрөлжсөн мэргэжлийн байгууллагуудаас (Байгалийн голомтот халдварт өвчнийг эсэргүүцэж судлах газар, Сүрьеэ судлалын төв гэх мэт) зохиох ажлыг уялдуулан зохицуулах;

11. Эрүүл мэндийн байгууллагын хэрэгцээт биобэлдмэл (бүх төрлийн вакцин, эмчилгээний ийлдэс, цусны болон нянгийн гаралтай эмчилгээ, сэргийлэлтийн бэлдмэл, нян, вирус, ийлдэс, паразит судлалын шинжилгээний оношлуур, сонгомол ба ялган дүйх тэжээлт орчин, халдварт ба халдварт бус харшлын аллерген)-ийн хэрэгцээг тогтоож, үйлдвэрлэх, экспорт, импортыг эрхлэх замаар хангах, энэ талаар нэгдсэн бодлого боловсруулан хэрэгжүүлэх ажлыг хариуцан гүйцэтгэх;

12. Эрдэм судлалын ажлын онол, арга зүйн түвшин, практик өгөөжийг байнга дээшлүүлж, судалгааны орчин үеийн арга зүй, технологи боловсруулах, нэвтрүүлэх, сурталчлах ажил хариуцах;

13. Халдварт өвчний дэгдэлт, экологийн болон хөдөлмөр, ахуйн нөхцөлөөс хамааран гарсан өвчин эмгэгийн шалтгааныг тогтоож таслан зогсоох, түүний үр дагаврыг арилгах ажилд мэргэжлийн туслалцаа үзүүлж, дүгнэлт, зөвлөмж гаргах;

14. Бэлгийн замаар дамжих өвчин (БЗДӨ), ДОХ-тэй тэмцэх ажлын удирдлагын арга зүй, мэдээлэл, сургалт, эрдэм шинжилгээ, сурталчилгаа, оношлогоо, эмчилгээний ажлыг эрхлэн гүйцэтгэх;

15. Халдварт өвчтөнд үзүүлэх эмчлэн сэргийлэх, нөхөн сэргээх

тусламжийн бодлого, чиглэлийг тодорхойлж, хэрэгжүүлэх, онош, эмчилгээний чанар, үр дүнг дээшлүүлэх арга замыг боловсруулж, орон нутгийн байгууллагад мэргэжлийн туслалцаа үзүүлж байх;

16. Эрүүл мэндийн мэдээллийг цуглуулах, боловсруулах, задлан шинжлэл хийж хүн амын өвчлөл, эндэгдлийн асуудлаар эн тэргүүнд анхаарах чиглэлийг тогтоох, эрүүл мэндийн салбарын мэдээллийг боловсронгуй болгох арга хэмжээг зохион байгуулах;

17. Төв нь нийгмийн эрүүл мэнд, хүн амын халдварт өвчин, хүрээлэн буй орчны нөлөөллийн шалтгаантай өвчлөл, эндэгдлийн шалтгааныг судлан тогтоож, тахир дутуу болгох өвчнөөс сэргийлэх, хүрээлэн буй орчныг бохирдлоос хамгаалах, экологийн тэнцвэр, хоол хүнсний чанар, аюулгүй байдлыг хангах асуудлаар баримтлах улсын бодлого, салбар дундын үйл ажиллагааны чиглэл, хөтөлбөр, төсөл, санал боловсруулж хэрэгжилтэд хяналт тавих, сургалт, сурталчилгаа явуулах;

18. Нийгмийн эрүүл мэндийн тулгамдсан асуудлаар Монгол улсын хууль, тогтоол, Засгийн газар, Эрүүл мэндийн яамнаас баталсан хөтөлбөрүүдийг (Монгол улсын дархлалын үндэсний хөтөлбөр, Вируст гепатит, ДОХ, Бруцеллёз өвчний хөтөлбөр, гэх мэт) хэрэгжүүлэх ажлыг удирдан зохион байгуулж, биелэлтэд хяналт тавих;

19. Нийгмийн эрүүл мэндийн нэн чухал асуудлаар олон улсын байгууллага, гадаад орнуудтай хамтарсан хэлбэрээр хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөрийг санаачлах, хариуцан гүйцэтгэх;

6. Төв нь дор дурдсан эрх эдэлнэ.

1. Хяналт, шалгалтыг эрүүл ахуй, халдвар судлалын улсын хяналтын дүрмийн дагуу хэрэгжүүлэхтэй холбогдох үйл ажиллагааг эрх зүйн болон мэргэжлийн талаас бие даан буюу холбогдох байгууллагуудаар шийдвэрлүүлэх, удирдан зохицуулна.

2. Үйл ажиллагаагаа явуулахад шаардагдах мэдээ, судалгаа,

баримт бичиг, тодорхойлолт бусад материалыг холбогдох байгууллага, албан тушаалтан, иргэдээс шаардаж гаргуулна.

3. Шаардлагатай асуудлаар холбогдох байгууллагатай тохиролцооны үндсэн дээр шинжээч, шинжээчийн хэсэг томилох, холбогдох лабораториудыг дайчлан шинжилгээ, хяналт хийлгэж, магадлагаа дүгнэлт гаргуулна.

4. Яам, тусгай газар, аймаг, нийслэлийн Засаг дарга, улс, хоршоолол, олон нийт, хувийн (тэдгээрийн дотор гадаадын ба хувь нийлүүлсэн), үйлдвэр, үйлчилгээ, аж ахуйн газар, албан байгууллагын удирдлагын шийдвэрийн дагуу хэрэгжүүлж буй үйл ажиллагаа нь эрүүл ахуй, халдвар судлалын хэм хэмжээнд харшилж, хүний эрүүл мэндэд хор хохирол учруулахаар байвал уг шийдвэрийг хүчингүй болгохыг шаардах, шаардлагатай гэж үзвэл тухайн шийдвэрийн дагуу хэрэгжүүлж буй үйл ажиллагааг зогсооно.

5. Монгол улсын хууль, тогтоолыг зөрчсөнөөс хүн амын эрүүл мэндийг хохироосон буюу хохироох нөхцөл бүрдүүлсэн гэм буруутай этгээдээр хохирол, зардлыг төлүүлэх асуудлыг хуулийн байгууллагад тавьж шийдвэрлүүлнэ.

6. Эрүүл ахуй, халдвар судлалын зөрчлийн шалтгаан нөхцлийг тогтоож, түүнийг арилгах талаар байгууллагын захиргаа, эздэд албан шаардлагыг хугацаатай өгч, гүйцэтгэлийг хангуулна.

7. Хэрэглэгчдээс эрүүл ахуй, халдвар судлалын зөрчилтэй холбогдуулан тавьсан хүсэлт, санал, гомдлыг хянаж холбогдох хууль, тогтоолын дагуу барагдуулна.

8. Үйлдвэрийн бүтээгдэхүүн, хоол, хүнсний зүйл, тэдгээрт хэрэглэх түүхий эд, сав, баглаа, боодол нь эрүүл ахуй, халдвар судлалын шаардлага хангаагүй, хүний эрүүл мэндэд хор хохирол учруулахаар байгаа нь нотлогдвол энэ тухай нийтэд зарлан сэрэмжлүүлэх, сурталчилна.

9. Эрүүл ахуй, халдвар судлалын байцаагчдын үйл ажиллагаанд үнэлэлт, дүгнэлт өгөх, тэдгээрийн гаргасан шийдвэр нь хууль тогтоомжид нийцэж байгаа эсэхэд хяналт тавьж, зөрчлийг арилгуулна.

10. Төвийн бүтэц, зохион байгуулалтыг тогтоож, үндсэн сан, эргэлтийн хөрөнгө, санхүүгийн бусад нөөцөөс бүрдэх эд хөрөнгийг хууль тогтоомжийн дагуу ашиглан, захиран зарцуулна.

11. Төвийн хэмжээнд мөрдөгдөх заавар, журам, шинжилгээний арга, аргачлал, техникийн нөхцөл, технологийн заавар батлаж мөрдүүлнэ.

12. Эрүүл ахуй, халдвар, нян, вирус судлал, халдварт өвчний асуудлаар эрдэм шинжилгээний бүтээл, нэг сэдэвт зохиолд шүүмж гаргаж, эрдмийн зэрэг горилогчийн болон урьдчилсан хамгаалалтын асуудал хэлэлцэж, санал, дүгнэлт гаргана.

13. Бусад байгууллага, иргэнтэй шууд харьцаж гэрээ байгуулж хэлцэл хийнэ.

14. Төвийн үйлдвэрлэл, технологийн шууд хамаарах мэдээлэл тогтооно.

15. Өөрийн ажилтнуудын цалингийн жишиг, мэргэжлийн зэрэг, цол, ур чадварын нэмэгдэл хөлсний хэмжээг хууль тогтоомжийн дагуу тогтоож мөрдөнө.

16. Боловсон хүчин, гадаад харилцаа, санхүү, аж ахуй, лабораторийн материаллаг баазыг бэхжүүлэх асуудлаар дотоод, гадаадын үйл ажиллагааг бие даан явуулна.

17. Олон улсын болон улс хоорондын хурал, зөвлөлгөөн, үзэсгэлэн яармаг, үнэ хаялцуулах худалдаанд оролцох замаар өөрийн үйлдвэрийн бүтээгдэхүүн, эрдэм судлалын ажлын үр дүнг сурталчлах, туршлага судлах, зах зээл сонгох, эдийн засгийн үр ашигтай худалдааг хөгжүүлэх арга хэмжээ авна.

18. Төвийн захирал нь дотоод, гадаадын байгууллагуудтай хариу-

дах байгаа асуудлаа итгэмжлэгчгүйгээр харилцах, зохих журмын дагуу гэрээ хэлцэл байгуулах, итгэмжлэл олгох, ажилтанг авах, ажлаас халах, тэднийг шагнах урамшуулах, сахилгын арга хэмжээг холбогдох хууль тогтоомжийн дагуу авна.

19. Төвөөс байгуулж байгаа гадаад худалдаа, хамтын ажиллагааны гэрээнд хоёр этгээд зохих журмын дагуу гарын үсэг зурна. Гэрээнд гарын үсэг зурах эрхийг Төвийн захирал, түүний итгэмжлэлээр эрх олгогдсон бусад албан тушаалтан эдэлнэ.

оОо

Эрүүл мэндийн сайд, Нийслэлийн Засаг дарга, Улаанбаатар хотын захирагчийн 1994 оны А/110/А-183 тоот хамтарсан тушаал, захирамжийн хоёрдугаар хавсралт

## АРЬСНЫ ӨВЧИН СУДЛАЛЫН ТӨВИЙН ДҮРЭМ

### Нэг. Нийтлэг үндэслэл

1. Арьсны өвчин судлалын төв нь (цаашид төв гэж нэрлэх) Монгол улс, нийслэлийн хэмжээнд арьсны өвчнийг оношлох, эмчлэх, урьдчилан сэргийлэх болон сургалт, судалгаа, эрдэм шинжилгээний ажлыг холбогдох байгууллагуудын оролцоотойгоор гүйцэтгэх мэргэжлийн төв байгууллага юм.

2. Төв нь Монгол улсын хууль, тогтоомж болон энэ дүрмийг удирдлага болгон ажиллана.

3. Төв нь Эрүүл мэндийн яамнаас мэргэжлийн удирдлага арга бодлогыг нь хэрэгжүүлж, нийслэлээс аж ахуй, зохион байгуулалт, санхүүгийн удирдлага авч ажлаа Эрүүл мэндийн яам, Нийслэлд тайлагнаж, хариуцна.

4. Төвийг Эрүүл мэндийн сайд, Нийслэлийн засаг даргын томилсон захирал удирдах ба тус төвд хариуцуулсан үүргийг хэрэгжүүлэх болон эмнэлэг, үйлчилгээний асуудлыг хамтын удирдлагын зарчмаар хэлэлцэн шийдвэрлэх зорилгоор захирлын зөвлөл ажиллуулж болно. Зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журмыг төвийн захирал батлан мөрдүүлнэ.

6. Төвийн захирал нь Арьсны өвчин судлалын төвд хариуцуулсан үүргийг хэрэгжүүлэн биелүүлэх ажлыг Эрүүл мэндийн яам, нийслэлийн өмнө хариуцна.

7. Арьсны өвчин судлалын төв нь арьсны өвчтөнд зөвлөгөө өгөх төрөлжсөн нарийн мэргэжлийн кабинет бүхий (поликлиник) үзлэгийн газар, төрөлжсөн нарийн мэргэжлийн тасаг бүхий клиник, лабораториуд, эмийн сан, нөхөн сэргээх эмгэй эмчилгээний тасаг, угаалга, ариутгал, гуанз, аж ахуй-санхүүгийн тасагтай ажиллана.

8. Арьсны өвчин судлалын төв нь тогтоосон журмаар хийсэн тэмдэг, бичгийн хүүр, албан бичгийн хэвлэмэл хуудастай байна.

Хоёр. <u>Арьсны өвчин судлалын төвийн үүрэг</u>

1. Арьсны өвчин оношлох, эмчлэх, урьдчилан сэргийлэх, тэмцэх болон эмчилгээний гоо заслын мэргэжлийн удирдлагаар хангах, үйлчилгээг нийслэл, улсын хэмжээнд зохион байгуулах бодлого боловсруулж хэрэгжүүлэх ажлыг эрхлэх;

2. Нийслэл, улсын хэмжээнд онош тодруулах, эмчлүүлэх, зөвлөгөө авах шаардлагатай хүмүүсийг тус төлд хүлээн авч, арьсны эмчийн нарийн мэргэжлийн тусламжийг үзүүлэх;

3. Арьсны өвчин судлалын чиглэлээр эрдэм судлалын ажил явуулах ба эмч, эмнэлгийн ажилтны мэргэжил дээшлүүлэх;

4. Хэвтэж эмчлүүлэх өвчтөнд тохитой байж эмчлүүлэх бүхий л нөхцлийг бүрдүүлж өгөх;

5. Арьсны өвчнөөс урьдчилан сэргийлэх, өвчлөхгүй байх, түүнтэй тэмцэх талаар ухуулга, сурталчилгааны ажлыг олон хэлбэрээр өргөн зохиох;

6. Арьсны өвчний өвчлөлийн мэдээ, тайланг тогтоосон хугацаанд авч нэгтгэн дүгнэлт хийж, арга хэмжээ боловсруулж хэрэгжүүлэх ажил зохиох;

7. Төвийн захиргаа хөдөлмөрийн хамт олны ажиллах нөхцлийг сайжруулах талаар дээд зэргийн анхаарал тавьж ажиллах;

8. Төв, орон нутгийн мэргэжлийн байгууллагуудыг мэргэжлийн удирдлагаар хангах, зааварчлах, шалган туслах, зөвлөгөө өгөх;

9. Аймаг, нийслэлийн мэргэжлийн байгууллагуудын хэрэгцээ, шаардлагыг үндэс болгон эм, хэрэгслээр хангах судалгаа хийж, захиалан хуваарилах ажлыг зохион байгуулах;

Гурав. Арьсны өвчин судлалын төвийн эрх

Тус төв нь дараах эрх эдэлнэ.

1. Төвийн захирал нь эрх хэмжээнийхээ дагуу Монгол улсын хууль, тогтоомжид нийцүүлэн тушаал, шийдвэр гаргаж, биелэлтийг зохион байгуулна.

2. Арьсны өвчин судлалын төв нь хуулийн этгээдийн эрх эдэлнэ.

3. Төв нь банкинд харилцах данстай байх бөгөөд бусад байгууллага, аж ахуйн нэгжтэй гэрээ, хэлцэл хийх эрх эдэлнэ.

4. Гадаад орны ижил, үйлчилгээ нэгтэй эрдэм шинжилгээ, сургалт, практикийн байгууллага, хүмүүстэй холбоо тогтоож, хамтран ажиллах, харилцан туршлага солилцох, гэрээ хэлцэл хийх, төлөөлөгч, ном хэвлэл солилцох болон ном товхимол, бүтээлийн түүвэр хэвлүүлэх зэргээр хамтран ажиллана.

5. Мэргэжлийн чиглэлээр онол-практикийн хурал, зөвлөгөөн, семинар, сургалт зохиохоос гадна арьсны өвчний талаар гарсан шинэ бүтээл, тэргүүн туршлага, дэвшилтэт технологи, аргачлал зэрэгт экспертизийн үнэлгээ, дүгнэлт өгнө.

6. Арьсны өвчин судлал, эмчилгээний гоо засалын чиглэлээр сургалтын бааз болж ажиллана.

oOo

Эрүүл мэндийн сайд, Нийслэлийн Засаг дарга, Улаанбаатар хотын захирагчийн 1994 оны А/110/А-183 тоот хамтарсан тушаал, захирамжийн гуравдугаар хавсралт

# НИЙСЛЭЛИЙН ЭРҮҮЛ АХУЙ, ХАЛДВАР СУДЛАЛЫН ТӨВИЙН ДҮРЭМ

## Нэг. Нийтлэг үндэслэл

1. Нийслэлийн эрүүл ахуй, халдвар судлалын төв нь (цаашид энэ дүрэмд Төв гэнэ) нийслэл, түүний дүүргүүдийн нутаг дэвсгэрт эрүүл ахуй, халдвар судлалын улсын хяналт, халдварт өвчинтэй тэмцэх, сэргийлэх арга хэмжээг удирдан чиглүүлэх, зохион байгуулах, хэрэгжүүлэх үүрэг бүхий мэргэжлийн байгууллага мөн.

2. Төв нь өөрийн үйл ажиллагаандаа Монгол улсын хууль тогтоомж, эрүүл ахуй, халдвар судлалын улсын хяналтын дүрэм, эрүүл мэндийн сайдын тушаал, нийслэлийн Засаг даргын захирамж, Эрүүл мэндийн газар, Эрүүл ахуй, халдвар, нян судлалын үндэсний төвийн шийдвэрийг удирдлага болгоно.

3. Төв нь нийслэлийн төсвөөс санхүүжих ба мэргэжлийн удирдлагаар Эрүүл ахуй, халдвар, нян судлалын үндэсний төв хангана.

4. Төвийг Эрүүл мэндийн сайд, Нийслэлийн засаг даргын томилсон захирал удирдана.

5. Төв нь ажлаа Нийслэлийн засаг дарга, Эрүүл ахуй, халдвар, нян судлалын үндэсний төвд давхар тайлагнана.

6. Төвийн захирал нь нийслэлийн эрүүл ахуй, халдвар, судлалын ерөнхий байцаагч байна. Ерөнхий байцаагчийг Нийслэлийн Тамгын газартай зөвшилцөн улсын ерөнхий байцаагч томилно.

7. Төвийн захирал нь Монгол улсын хууль тогтоомж, Эрүүл мэндийн яам, Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Эрүүл ахуй, халдвар, нян судлалын үндэсний төвийн шийдвэрт нийцүүлэн Нийслэл хотын хэмжээнд болон Эрүүл ахуй, халдвар судлалын хяналтын албa,

хэсэг, тэдгээрийн албан тушаалтныг үйл ажиллагаандаа даган мөрдөх тушаал гаргаж, түүний хэрэгжилтийг зохион байгуулж, хяналт тавина.

8. Эрүүл ахуй, халдвар судлалын хяналтыг Нийслэлийн Эрүүл ахуй, халдвар судлалын төв, түүний харъяа дүүргийн эрүүл ахуй, халдвар судлалын алба, хэсэг, тэнд ажиллаж байгаа байцаагчид эрхлэн гүйцэтгэх ба байцаагчдыг Эрүүл ахуй, халдвар судлалын улсын хяналтын дүрмийн дагуу томилох буюу чөлөөлнө.

9. Төв нь Эрүүл ахуй, халдвар судлалын улсын хяналтын дүрмийг хэрэгжүүлэхтэй холбогдсон асуудлыг хэлэлцэн шийдвэрлэж байх захирлын зөвлөл, захиргаа, дотоод ажил, санхүүгийн ажиллагааг зохион байгуулах, шийдвэр гаргах үүрэг бүхий захиргааны зөвлөлтэй байна. Захирлын болон захиргааны зөвлөлийн гишүүдийг төвийн захирал томилж удирдана.

10. Төв нь хуулийн этгээдийн эрх эдэлж, зохих журмын дагуу хийлгэсэн тэмдэг, албан бичгийн нүүр, хэвлэмэл хуудас хэрэглэнэ.

Хоёр. Төвийн үүрэг, эрх

А. Төв нь дор дурдсан үүрэг гүйцэтгэнэ.

1. Эрүүл ахуй, халдвар судлалын улсын хяналтын дүрмийг хэрэгжүүлэх ажлыг Нийслэл хотын хэмжээнд удирдан зохион байгуулах;

2. Эрүүл ахуй, халдвар, хор судлалын холбогдолтой хууль, тогтоомж, норм, норматив, стандарт, дүрэм, зааврыг Нийслэлийн нутаг дэвсгэрийн бүх байгууллага, аж ахуйн нэгж, албан тушаалтан, иргэдээс хэрхэн мөрдөж байгааг байнга хянан шалгах биелэлтийг хангуулах;

3. Хөдөлмөр, орчин, сургалт, хоол хүнс, эрүүл ахуйн нөхцөл, байгаль, экологи, нийгмийн сөрөг хүчин зүйлийн нөлөөллөөс үүсэх өвчин эмгэгээс хүн амыг хамгаалах, урьдчилан сэргийлэх асуудлаар бодлого боловсруулж, бусад холбогдох байгууллагатай хамтран нутаг дэвсгэрийн хэмжээнд хэрэгжүүлэн, биелэлтэд нь хяналт тавих;

4. Хот, суурин байгуулах ерөнхий төлөвлөгөө, барилга байгуу-

лангийн болон технологийн зураг төсөл зохиох, барилга барих газар, ус хангамжийн эх булгийн байршил сонгох, эдгээрийг барьж байгуулах, ашиглалтад оруулахад эрүүл ахуйн норм, нормативыг хэрхэн мөрдөж байгаад хяналт тавих;

5. Үйлдвэр, үйлчилгээний технологи, тоног төхөөрөмж, бүтээгдэхүүн, түүхий эд, унд ахуйн хэрэгцээний ус, хүнсний зүйл, сав баглаа боодол, биобэлдмэл тэдгээрийг хэрэглэх, хадгалах, тээвэрлэх, худалдаалах үйл ажиллагаа, эрүүл ахуйн нөхцөл шаардлагад нийцэж буй эсэхэд хяналт тавьж, холбогдох арга хэмжээ авах;

6. Химийн бодис, физикийн хүчин зүйл, иргэдийн эрүүл мэнд, амьдралын хэвийн үйл ажиллагаа, бие махбодийн эсэргүүцэх чадварт сөрөг нөлөө үзүүлж байгаа эсэхийг хянан шалгах;

7. Нийслэл хотын хэмжээнд халдварт өвчин болон хүн амын өвчлөл, эндэгдэлд зонхилох суурь эзэлж байгаа бусад өвчинтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх талаар зохиож байгаа ажилд хяналт тавих, тэдгээр өвчний шалтгаан, нөхцөлийн байдалд судалгаа хийж, шаардлагатай арга хэмжээ авч ажиллах;

8. Халдварт өвчнөөр өвчилсөн өвчтөнд үзүүлэх түргэн тусламжийн үйлчилгээ, диспансерийн хяналт, халдвар судлал, голомтын болон өвчний дэгдэлтийг таслан зогсоох, халдвар эсэргүүцэх арга хэмжээг зохион байгуулж хэрэгжүүлэх;

9. Халдварт өвчнөөс сэргийлэх тарилгыг төлөвлөх, зохион байгуулах, хяналт тавих;

10. Нийслэл хотын хэмжээнд хийгдэх нян судлалын шинжилгээний үйлчилгээг гүйцэтгэх;

Б. Төв нь дор дурдсан эрх эдэлнэ.

1. Төв нь эрүүл ахуй, халдвар судлалын асуудлаар өөрийн орны ба гадаадын мэргэжлийн байгууллагатай шууд харилцаа тогтоож, мэдээлэл солилцох, хамтран ажиллана.

2. Төв нь ажилтан, ажилчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэж, өөрийн материаллаг бааз, боловсон хүчний хангамж, хүрэлцээг сайжруулах, боловсон хүчнийг бэлтгэх бодлого, чиглэлийг боловсруулж, мэргэжил олгох, дээшлүүлэх, давтан сургах ажлыг системтэй зохион байгуулах, тэднийг үр бүтээлтэй ажиллуулах, хөдөлмөр, нийгэм ахуйн нөхцөлийг сайжруулж, цалинг нэмэгдүүлэх арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

3. Төв нь байгууллага, аж ахуйн нэгжүүдийн удирдлагын шийдвэр, түүний хэрэгжилт, үйл ажиллагаа нь эрүүл ахуй, халдвар судлалын хэм хэмжээнд харшлах, хүний эрүүл мэндэд хохирол учруулах үндэстэй байвал уг шийдвэрийг хүчингүйд тооцохыг шаардах, шаардлагатай гэж үзвэл тухайн шийдвэрийн дагуу хэрэгжүүлж буй үйл ажиллагааг уул зөрчлийг арилгах хүртэлх хугацаанд зогсоож байна.

4. Эрүүл ахуй, халдвар судлалын холбогдолтой зөрчил, халдварт өвчнөөс сэргийлэх асуудлаар сурталчилгаа, зарлан мэдээлэл явуулна.

5. Эрүүл ахуй, халдвар судлалын хяналтыг онцгой тохиолдолд өвөрмөц хэлбэрээр зохион байгуулж тодорхой байгууллага, нутаг орчинд мөрдөх болох журам, түүнийг хэрэгжүүлэх арга зүйн эрхийн актуудыг Нийслэлийн засаг дарга, Засаг даргын Тамгын газар, Эрүүл мэндийн газарт тавьж шийдвэрлүүлнэ.

6. Өөрийн ажилтнуудын цалингийн жишиг, мэргэшлийн зэрэг цол, ур чадварын нэмэгдэл, хөлсний хэмжээг хууль, тогтоолын дагуу тогтоож мөрдөнө.

7. Төвийн захирал нь дотоод, гадаадын байгууллагатай гэрээ, хэлцэл байгуулах, ажилтныг авах, ажлаас халах, тэднийг шагнаж урамшуулах, сахилгын арга хэмжээг хууль, тогтоолын дагуу авах эрх эдэлнэ.

8. Үйл ажиллагаа явуулахад шаардагдах мэдээ, судалгаа, баримт бичиг, бусад материалыг холбогдох байгууллага, албан тушаал-

тан, иргэдээс шаардаж гаргуулна.

9. Монгол улсын хууль, тогтоомжийг зөрчсөнөөс хүн амын эрүүл мэндийг хохироосон буюу хохироох нөхцөл бүрдүүлсэн гэм буруутай этгээдээр хохирол зардлыг төлүүлэх асуудлыг хуулийн байгууллагад тавьж шийдвэрлүүлнэ.

оОо